



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ УТҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Аудитор: А.Даваадорж
Утас: 261740 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn
Гэрээгээр гүйцэтгэсэн:
Нью Эстимэйтор Аудит ХХК Захирал Т.Бүжидмаа
Утас: 95157097 Цахим хаяг: jukhertar@yahoo.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
1.Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	10
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт	17
4.1 Залруулсан алдаа	17
4.2 Албан шаардлага	17
4.3 Зөвлөмж	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар
ҮЦХ	Үндсэн хуулийн цэц



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ
УТУГ-ЫН ЗАХИРАЛ Г.ЧИНЗОРИГ
ТАНАА

2022.03.15 № 07/551
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Засгийн газрын авто бааз УТУГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Засгийн газрын авто бааз УТУГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	930,485,695.68	1,190,728,224.29
1.1.2	Дансны авлага	103,959,463.38	163,658,334.72
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад богино хугацаат авлага	190,935,842.00	208,944,036.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	74,588,729.31	83,308,031.68
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	8,819,809.13	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10		-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,308,789,539.50	1,646,638,626.70
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.1	Үндсэн хөрөнгө	13,748,434,509.22	13,120,755,582.51
1.2.2	Биет бус хөрөнгө	718,836,000.00	721,242,249.97
1.2.3	Биологийн хөрөнгө	44,521,000.00	43,812,000.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9		-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	14,511,791,509.22	13,885,809,832.48
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,820,581,048.72	15,532,448,459.18
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	Өр төлбөр	-	-
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.1	Дансны өглөг	33,685,500.00	36,487,900.00
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-

2.1.1.3	Татварын өр	-	-
2.1.1.4	НДШ-ийн өглөг	-	-
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	7,385,036.73	2,193,747.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	4,927,864.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	41,070,536.73	43,609,511.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр /хойшлогдсон орлого/	2,483,104,135.65	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,483,104,135.65	-
2.2.20	Өр төлбөрийн нийт дүн	2,524,174,672.38	43,609,511.00
2.3	Эздийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	11,744,520,814.45	11,744,520,814.45
2.3.2	- хувийн	-	-
	- хувьцаат	-	-
2.3.3	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	-
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,132,191,677.04	2,132,191,677.04
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	718,836,000.00	718,836,000.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,299,142,115.15)	893,290,456.69
2.3.10		-	-
2.3.11	Эздийн өмчийн дүн	13,296,406,376.34	15,488,838,948.18
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,820,581,048.72	15,532,448,459.18

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,599,754,941.15	1,751,009,842.07
2	Борлуултын өртөг	2,394,376,243.98	1,554,508,209.49
3	Нийт ашиг (алдагдал)	(794,621,302.83)	196,501,632.58
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Татаас санхүүжилтийн орлого	2,995,255,300.00	3,137,554,600.00
8	Бусад орлого	668,344,151.80	1,555,851,038.71
9	Борлуулалт, маркетингийн зардал	3,787,851,983.11	3,896,129,058.87
10	Ерөнхий ба удирдлагын зардал	110,548,393.00	1,185,017,288.88
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	174,899.08	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	(272,356,579.63)	(99,432,487.34)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,301,603,907.69)	(290,671,563.81)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,301,603,907.69)	(290,671,563.81)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,301,603,907.69)	(290,671,563.81)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(1,301,603,907.69)	(290,671,563.81)
25	Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,744,520,814.45	2,132,191,677.04	718,836,000.00	2,461,792.54	14,598,010,284.03
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-
Залруулсан үлдэгдэл	11,744,520,814.45	2,132,191,677.04	718,836,000.00	2,461,792.54	14,598,010,284.03
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(1,301,603,907.69)	(1,301,603,907.69)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,744,520,814.45	2,132,191,677.04	718,836,000.00	(1,299,142,115.15)	13,296,406,376.34
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	2,483,104,135.65	2,483,104,135.65
Залруулсан үлдэгдэл	11,744,520,814.45	2,132,191,677.04	718,836,000.00	1,183,962,020.50	15,779,510,511.99
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(290,671,563.81)	(290,671,563.81)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	11,744,520,814.45	2,132,191,677.04	718,836,000.00	893,290,456.69	15,488,838,948.18

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	Мөнгөн орлогын дүн	4,853,942,250.86	5,532,040,258.38
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,545,152,765.50	1,618,333,543.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	19,525,500.00	75,567,624.91
1.1.4	Буцаан авсан албан татвар	-	-
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,995,255,300.00	3,137,554,600.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	294,008,685.36	700,584,490.47
1.2	Мөнгөн зарлагын дүн	4,699,273,696.51	5,229,993,229.77
1.2.1	Ажиллагчдад төлсөн	2,029,209,953.00	2,195,058,318.57
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	653,372,521.38	695,402,967.62
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,732,200.00	12,439,215.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	253,115,460.92	166,159,687.55
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	844,809,835.80	983,373,873.50
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	202,736,966.63	193,890,425.52
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн мөнгө	-	-
1.2.9	Бусад мөнгөн зарлага	712,296,758.78	983,668,742.01
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	154,493,655.27	302,047,028.61
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
2.1	Мөнгө орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	-	-
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	-	-

2.2	Мөнгөн зарлагын дүн	36,245,614.00	41,804,500.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	36,245,614.00	41,804,500.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(36,245,614.00)	(41,804,500.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
3.2.4	Төлсөн ногдол ашиг	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	118,422,940.35	260,242,528.61
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	812,062,755.33	930,485,695.68
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	930,485,695.68	1,190,728,224.29

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Нийт төлбөрт гүйлт /мян.км/	км	2,452,118.00	2,944,800.00	2,659,500.00	(285,300.00)	90.3
Нийт орлого	төгрөг	5,263,671,739.60	5,624,129,200.00	6,444,415,480.78	820,286,280.78	114.6
Үндсэн үйл ажиллагааны орлого	төгрөг	1,599,754,941.15	1,912,704,000.00	1,751,009,842.07	161,694,157.93	91.5
Үндсэн үйл ажиллагааны бус орлого	төгрөг	668,661,498.45	573,870,000.00	1,555,851,038.71	(981,981,038.71)	271.1
Улсын төсвийн санхүүжилт	төгрөг	2,995,255,300.00	3,137,555,200.00	3,137,554,600.00	600.00	100.0
Нийт зардал	төгрөг	6,565,275,647.29	5,619,255,600.00	6,735,087,044.59	(1,115,831,444.59)	119.9
Үндсэн үйл ажиллагааны	төгрөг	6,060,976,775.27	5,256,655,600.00	6,506,412,335.25	(1,255,444,077.25)	123.8
Цалин	төгрөг	2,640,146,858.00	2,662,449,200.00	2,629,179,489.00	33,269,711.00	98.8
Шимтгэл	төгрөг	354,229,260.24	332,806,100.00	365,892,661.60	(33,086,561.60)	109.9
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	төгрөг		142,299,900.00	142,299,900.00	-	100.0
Шатахуун, тослох материал	төгрөг	913,803,158.31	824,930,300.00	1,010,125,588.12	(185,195,288.12)	122.4
Сэлбэг, засвар үйлчилгээ	төгрөг	379,711,391.50	397,270,000.00	366,396,143.10	30,873,856.90	92.2
Цахилгаан	төгрөг	67,967,775.00	76,483,200.00	64,615,388.72	11,867,811.28	84.5
Дулаан	төгрөг	73,892,883.92	75,486,700.00	80,447,857.83	(4,961,157.83)	106.6
Ус	төгрөг	14,072,993.00	14,051,600.00	11,859,381.00	2,192,219.00	84.4
Холбоо, радио, телевизийн зардал	төгрөг	7,996,411.88	8,184,000.00	6,142,666.09	2,041,333.91	75.1
Томилолт	төгрөг	68,744,051.13	88,400,000.00	60,541,000.00	27,859,000.00	68.5
Элэгдлийн зардал	төгрөг	1,201,427,575.47	-	1,503,578,362.79	(1,503,578,362.79)	
Хөдөлмөр хамгаалал, хангамжийн зардал	төгрөг	19,357,400.00	19,004,000.00	-	19,004,000.00	
Автомашин засвар, оношилгоо	төгрөг	3,889,356.00	4,500,000.00	4,083,900.00	416,100.00	90.8
Удирдлагын зардал	төгрөг	2,253,532.00	2,520,000.00	-	2,520,000.00	
Бичиг хэрэг, аж ахуйн зардал	төгрөг	65,647,812.00	23,441,000.00	25,337,198.00	(1,896,198.00)	108.1
Зар сурталчилгаа	төгрөг	566,000.00	3,000,000.00	441,820.00	2,558,180.00	14.7
Тээврийн зардал	төгрөг	54,974,661.37	42,470,000.00	67,346,138.00	(24,876,138.00)	158.6
Үл хөдлөх хөрөнгө ба газрын татвар	төгрөг	8,912,704.00	13,000,000.00	8,912,702.00	4,087,298.00	68.6
Автомашин татвар, даатгал	төгрөг	89,955,379.00	101,751,600.00	105,127,522.00	(3,375,922.00)	103.3
Хөдлөх хөрөнгөтэй холбоотой бичиг баримт	төгрөг	2,027,888.00	3,000,000.00	2,958,812.00	41,188.00	98.6

Үйлчилгээний ба гэрээт ажлын хөлс	төгрөг	7,190,600.00	50,000,000.00	13,842,400.00	36,157,600.00	27.7
Урсгал болон барилгын засвар	төгрөг	40,604,688.00	168,841,000.00	33,917,570.00	134,923,430.00	20.1
Компьютер тоног төхөөрөмж ,тавилга авах	төгрөг	-	57,767,000.00	-	57,767,000.00	
Хоолны зардал	төгрөг	1,796,190.00	-	3,365,835.00	(3,365,835.00)	
Автомашин худалдаж авах зардал	төгрөг		135,000,000.00	-	135,000,000.00	
Аудитын зардал	төгрөг	19,420,000.00	10,000,000.00	-	10,000,000.00	
Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлсний гарз	төгрөг	22,188,358.88	-	-	-	
Найдваргүй авлагын зардал	төгрөг		-	-	-	
Үйл ажиллагааны бус	төгрөг	504,298,872.02	362,600,000.00	228,674,709.34	133,925,290.66	63.1
Ханшны өөрчлөлт, банкны үйлчилгээ	төгрөг	1,431,157.27	1,500,000.00	482,019.34	1,017,980.66	32.1
Шагнал, баяр ёслол	төгрөг	21,546,703.00	56,200,000.00	6,848,400.00	49,351,600.00	12.2
Тэтгэмж	төгрөг	49,854,917.00	56,000,000.00	48,848,488.00	7,151,512.00	87.2
Малын тэжээл, бусад	төгрөг	19,547,182.75	20,000,000.00	30,057,258.00	(10,057,258.00)	150.3
Эмнэлэг, спорт, сургалт, тэмцээний зардал	төгрөг	43,331,340.00	69,900,000.00	29,457,080.00	40,442,920.00	42.1
Тэтгэмжийн сан	төгрөг	-	15,000,000.00	-	15,000,000.00	
Түрээсийн орлогын төвлөрүүлэлт	төгрөг	216,556,829.00	100,000,000.00	111,981,464.00	(11,981,464.00)	112.0
Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөрийн хүрээнд	төгрөг	100,000,000.00	44,000,000.00	-	44,000,000.00	
Алданги, торгууль, шүүхийн шийдвэрийн зардал	төгрөг	57,030,743.00	-	1,000,000.00	(1,000,000.00)	
Татварын өмнөх ашиг	төгрөг	(1,301,603,907.69)	4,873,600.00	(290,671,563.81)	(295,545,163.81)	
ААНОАТатвар, НӨТатвар	төгрөг	-	487,400.00	-	487,400.00	
Цэвэр ашиг, алдагдал /+ -/	төгрөг	(1,301,603,907.69)	4,386,200.00	(290,671,563.81)	(295,057,763.81)	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлага, цахим төлбөрийн баримтын баталгаажуулалт, дотоод хяналттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Нью эстимэйтор аудит ХХК-ийн ахлах аудитор Ж.Үхэртар, аудитор Б.Халиунаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Т.Бүжидмаа хэрэгжүүлсэн.

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 1/20 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Засгийн газрын авто бааз нь төр, засгийн байгууллагуудад тээврийн үйлчилгээ үзүүлдэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгагдагч байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 5,263.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 105.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 84.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 288.2 сая төгрөгөөр буюу 1.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, урт хугацаат өр төлбөрийн дансууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	930,485.7	1,190,728.2	260,242.5
Авлага	294,895.3	372,602.4	77,707.1
Урьдчилгаа	8,819.8	-	(8,819.8)
Бараа материал	74,588.7	83,308.0	8,719.3
Үндсэн хөрөнгө	13,748,434.5	13,120,755.6	(627,678.9)
Биет бус хөрөнгө	718,836.0	721,242.2	2,406.2
Биологийн хөрөнгө	44,521.0	43,812.0	(709.0)
Нийт хөрөнгийн дүн	15,820,581.0	15,532,448.4	(288,132.6)
Өр төлбөрийн дүн	2,524,174.6	43,609.5	(2,480,565.1)
Богино хугацаат өглөг	41,070.5	43,609.5	2,539.0
Урт хугацаат өглөг	2,483,104.1	-	(2,483,104.1)
Эздийн өмч	13,296,406.4	15,488,838.9	2,192,432.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	15,820,581.0	15,532,448.4	(288,132.6)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 1,190.7 сая төгрөг болж 260.2 сая төгрөгөөр өссөн байна. Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэлд 0.02 сая, Төрийн банканд 199.1 сая, Худалдаа хөгжлийн банканд 822.4 сая, Хас банканд 169.2 сая, нийт 1,190.7 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 13,120.8 сая төгрөг болж, 627.7 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдлээс шалтгаалсан байна. Тайлант онд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 1,503.6 сая төгрөг болж, өмнөх оноос 302.2 сая төгрөгөөр нэмэгдсэн.

Хойшлогдсон орлого дансанд балансаас баланст шилжүүлэн авсан хөрөнгүүдийг бүртгэсэн байсныг үйл ажиллагааны бус орлогод залруулах бичилт хийснээр урт хугацаат өр төлбөр буурсан.

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,180.7 сая төгрөгөөр буюу 22.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан улсын төсвийн санхүүжилт, үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлого байна. Тээврийн үйлчилгээний орлогоор үндсэн үйл ажиллагааны орлого 151.3 сая, балансаас баланст шилжиж ирсэн хөрөнгөөр үндсэн бус үйл ажиллагааны орлого 826.6 сая, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжээр улсын төсвийн санхүүжилт 142.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх онтой харьцуулахад 169.8 сая төгрөгөөр нэмэгдсэн шатахууны үнэ тайлант онд 670 төгрөгөөр нэмэгдэж зардлыг өсгөсөн бол балансаас баланст шилжиж ирсэн хөрөнгийн элэгдлээр зардал мөн нэмэгдсэн байна.

3.6. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг нийт орлого 5,788.6 сая, зардал 7,513.4 сая төгрөг байхаар төлөвлөн дээд шатны байгууллагад хүргүүлсэн бөгөөд Төр засгийн үйлчилгээг эрхлэх газрын 2021 оны 3 дугаар сарын 5-ны 28 дугаар албан бичгээр төлөвлөгөөний төсөлд Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой хэмнэлтийг тооцон, өөрчлөлт оруулан батлуулах тухай чиглэл өгч түүний дагуу нийт орлогыг 5,624.1 сая, нийт зардлыг 5,619.3 сая, ашгийг 4.8 сая төгрөг байхаар батлуулсан байна. Хөрөнгө оруулалтын арга хэмжээ төсөв батлаагүй байна.

Гүйцэтгэлээр 6,444.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 6,735.1 сая төгрөгийн зардал гарган, 290.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл төлөвлөснөөс 820.3 сая төгрөг буюу 14.6 хувиар давсан нь балансаас баланст шилжүүлж авсан хөрөнгийг үйл ажиллагааны бус орлогод бүртгэснээс шалтгаалжээ.

Нийт зардлын гүйцэтгэл төлөвлөснөөс 1,115.8 сая төгрөг буюу 19.9 хувиар илүү гүйцэтгэлтэй байна. Энэ нь элэгдлийн зардлыг зорилтот түвшний төлөвлөгөөнд тооцоолж батлаагүйгээс шалтгаалсан байна. Тайлант оны элэгдлийн зардал 1,503.6 сая төгрөг болсон байна.

Тайлант онд 290.7 сая төгрөгийн цэвэр алдагдалтай гарсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

ТӨБЗГ-ын 2020 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 49 тоот тогтоолын дагуу тайлант онд түрээсийн төлбөрийн 40.0 хувь болох 107.1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг баталсан хэдий ч уг норм нь бодит гүйцэтгэлээс зөрүүтэй байгаагаас байгууллага бүр дотооддоо тус тушаалын 3 дугаар хавсралтын 1.3 “Автомашин насжилт, элэгдэл зэрэг хүчин зүйлээс хамааралтайгаар шатахуун зарцуулалтын жишиг нормоос шатахууны бодит зарцуулалт бага зэргийн зөрүүтэй байж болох бөгөөд судалгаагаар тогтоосон бодит зарцуулалтыг автомашины шатахуун зарцуулалтын үндсэн норм болгон мөрдөж болно” гэж заасныг үндэслэн шатахуун зарцуулалтын нормыг баталж үйл ажиллагаандаа мөрдөж байна. Иймд

тушаалаар баталсан нормыг дахин хянаж бодит гүйцэтгэлтэй уялдуулан өөрчилж, хэрэгжилтийг хангуулах шаардлагатай гэж үзэж байна.

3.8 Аудитын гол асуудал

Засгийн газрын авто бааз УТҮГ нь санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалын дагуу бэлтгэдэг, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайлан гаргадаг байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3. “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ”, 17 дугаар зүйлийн 1. “Улсын төсөвт үйлдвэрийн газар нь эд хөрөнгийн талаар энэ хуулийн 14 дүгээр зүйлд заасан төрийн байгууллага, албан газартай нэгэн адил эрхтэй”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”, 2 дугаар хавсралтаар “санхүүгийн тайлан, тодруулгын маягтууд”, 3 дугаар хавсралтаар “санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-тай тус тус нийцэхгүй байна. Иймд байгууллагын санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын дагуу бэлтгэх нь зүйтэй гэж үзэв.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хөрөнгө оруулалтаар барьсан 400 автомашины гараашийг бүрэн хүчин чадлын хэмжээнд ашиглахгүй байгаа буюу дүүргэлт 73.2 хувьтай байна. Иймд бусад төрийн байгууллагуудын автомашинуудыг тус гараашд байршуулдаг байхаар зохион байгуулалт хийж ашиглалтыг сайжруулах нь зүйтэй.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Засгийн газрын авто бааз УТҮГ нь тайлант онд нийт 5,394.9 сая төгрөгийн 260 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 20 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант оны баталсан төсвийг гүйцэтгэлтэй харьцуулан шалгахад бичиг хэрэг, аж ахуйн зардлыг 1.9 сая төгрөгөөр, тээврийн зардлыг 24.8 сая төгрөгөөр, хоолны зардлыг 3.4 сая төгрөгөөр, нийт 30.1 сая төгрөгөөр баталсан төсвөөс хэтрүүлж зарцуулсан байв.

Энэ нь Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 “Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.3 “төрийн болон орон нутгийн

өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Баталсан төсвийн хүрээнд хөрөнгийг зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгөх.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар 716.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад 621.2 сая төгрөгийн алдааг залруулж, 28.9 сая төгрөгийн зөрчлийг арилгасан, 65.9 сая төгрөгийн алдаа, зөрчил арилаагүй тул жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитын илрүүлэлтэд тусгасан.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 63.4 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд зөвлөмж өгснөөс албан шаардлага 13.8 хувь, зөвлөмж 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	2	63,398.7	-	8,794.2	2	54,604.5	13.8
Зөвлөмж	1	-	1	-			100.0
Нийт дүн	3	63,398.7	1	8,794.2	2	54,604.5	37.9

Дансанд бүртгэлгүй хөрөнгөтэй холбоотой зардал гаргахгүй байх, зөрүүтэй тайлагнасан 63.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, зөрчлийг давтан гарсан тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн шатны буюу төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тус байгууллага нь УТҮГ гэсэн статустай, улсын төсвөөс цалингийн зардлын санхүүжилтийг олгодог боловч санхүүгийн тайланг аж ахуйн нэгжийн загвараар бэлтгэн, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлдөг, ЗГХЭГ-ын дансанд бүртгэлтэй автомашиныг ашиглан орлого олж, зардал гаргаж байгаа зэрэг асуудлуудыг анхаарч үзэх, дотоод аудит хийж, шийдвэрлэх талаар уламжлах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,690.1 сая төгрөгийн 7 алдаа, зөрчил илэрснээс, 2,669.5 сая төгрөгийн 3 алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 20.6 сая төгрөгийн 3 зөвлөмж өглөө. Залруулагдаагүй 20.6 сая төгрөгийн алдаа, зөрчил нь тогтоосон 84.2 сая төгрөгийн түвшнээс 63.6 сая төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өгөв.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэл хөтлөлт, тайлагналын алдаатай дараах залруулгуудыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Балансаас баланст шилжиж ирсэн 2,617.2 сая төгрөгийн хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэсэн;
- Түрээсийн гэрээний дагуу орлогыг тулган шалгахад төлбөрийн үлдэгдэлтэй 3 харилцагчийн 11.4 сая төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй, авлага үүсгээгүй;
- Урсгал засварын зардал болон бусад зардлын 40.9 сая төгрөгийн гүйлгээг аж ахуйн зардалд бүртгэсэн.

4.2 Албан шаардлага

Өмнөх оны аудитаар өгсөн ЗГХЭГ-ын дансанд бүртгэлтэй, өөрийн дансанд бүртгэлгүй автомашиныг ашиглан орлого олж, зардал гаргасан зөрчлийг арилгах албан шаардлагын хэрэгжилт 13.8 хувьтай байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.5 “бүх орлого” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ЗГХЭГ-ын хөрөнгөд бүртгэлтэй 4 автомашинтай холбоотой үүсэх орлого, зарлагын тооцоог хоорондын гэрээгээр зохицуулах, хөрөнгийг бүртгэлтэй холбоотой асуудлыг дээд шатны төсвийн захирагчид хандан шийдвэрлүүлэх албан шаардлага хүргүүлэх.

4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЗГХЭГ-ын 2019 оны 4 дүгээр сарын 3-ны ХЭГ/866 тоот албан бичгийн дагуу Төр, нийгмийн зүтгэлтэн, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар маршал Юмжаагийн Цэдэнбалын Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшилд оруулсан гавьяа зүтгэл амьдралын баримтат, түүхэн үнэнийг харуулсан уран сайхны кино бүтээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хүмүүн фильмд тээврийн үйлчилгээ үзүүлж 81.0 сая төгрөгийн авлагын тооцоо үүссэн байна. Тус төслийн ажиллагаа зогссоноос шалтгаалан авлага төлөгдөхгүй, найдваргүй болох эрсдэлтэй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авлагыг барагдуулах арга хэмжээ авах.

Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 33 байгууллага, хувь хүнд олгосон 20.6 сая төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын 5-д “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалттай нийцээгүй, иж бүрэн байх, тохиолдсон байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан бараа, ажил үйлчилгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулах, системд хяналт тавин ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх.

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг дотоод хяналт, шалгалтын журамгүй байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолтой нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дотоод хяналт шалгалтын журмыг батлан, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
					Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Засгийн газрын авто бааз УТҮГ	АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ	Балансаас баланст шилжиж ирсэн хөрөнгийг хойшлогдсон орлогоор бүртгэсэн.	Балансаас баланст шилжиж ирсэн хөрөнгийг үйл ажиллагааны бус орлогод бүртгэж залруулав. Санхүү байдал, орлогын дэлгэрэнгүй тайланд залруулга хийв.	1	2,617,173.4	1	2,617,173.4						
2	Засгийн газрын авто бааз УТҮГ	АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ	Түрээсийн гэрээний дагуу орлогыг тулган шалгахад төлбөрийн үлдэгдэлтэй 3 харилцагчийн 11,368.0 мянган төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй, авлага үүсгээгүй байна.	Санхүү байдал, орлогын дэлгэрэнгүй тайланд залруулга хийв.	1	11,368.0	1	11,368.0						
3	Засгийн газрын авто бааз УТҮГ	АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ	Урсгал засварын зардал болон бусад зардлын 40,996.6 мянган төгрөгийн гүйлгээг аж ахуйн зардалруу ангилал андуурч бүртгэсэн.	Дансны ангиллыг зөв болгож залруулав.	1	40,996.6	1	40,996.6						
4	Засгийн газрын авто бааз УТҮГ	АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ	Тайлант онд 33 байгууллага, хувь хүнд олгосон 20,631.1 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж аваагүй байна.	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээг цахим төлбөрийн баримтаар баталгаажуулах, системд хяналт тавин ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх	1	20,631.1							1	20,631.1
5	Засгийн газрын авто бааз УТҮГ	АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ	ЗГХЭГ-ын 2019 оны 4 дүгээр сарын 3-ны ХЭГ/866 тоот албан бичгийн дагуу МУ-ын төр, нийгмийн зүтгэлтэн, БНМАУ-ын баатар, Хөдөлмөрийн баатар маршал Юмжаагийн Цэдэнбалын МУ-ын тусгаар тогтнол, хөгжил дэвшилд	Дээд шатны байгууллагаас чиглэн авч авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах талаар албан шаардлага хүргүүлэх;	1	-							1	-

			оруулсан гавьяа зүтгэл амьдралын баримтат, түүхэн үнэнийг харуулсан уран сайхны кино бүтээхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хүмүүн фильмд тээврийн үйлчилгээ үзүүлж 81,015.1 мянган төгрөгийн авлагын тооцоо үүссэн бөгөөд уг авлага 2 тайлант он дараалан төлөгдөөгүй, найдваргүй болох эрсдэлтэй байна.											
6	Засгийн газрын авто бааз УТҮГ	АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ	Өмнөх оны аудитаар ЗГХЭГ-ын дансанд бүртгэлтэй, өөрийн дансанд бүртгэлгүй автомашиныг ашиглан орлого олж, зардал гаргасан алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлсэн бөгөөд хэрэгжилт нь 13.8 хувьтай байна.	Дансанд бүртгэлгүй ЗГХЭГ-ын 4 автомашинтай холбоотой үүсэх орлого зарлагын тооцоог хоорондын гэрээгээр шийдвэрлэх, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага хүргүүлэх;	1	-					1	-		
7	Засгийн газрын авто бааз УТҮГ	АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ	Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг дотоод хяналт, шалгалтын батлагдсан журамгүй байна.	Дотоод хяналт шалгалтын журмыг батлан, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах	1	-							1	-
ДҮН					7	2,690,169.1	3	2,669,538.0			1	-	3	20,631.1
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал														
8	Засгийн газрын авто бааз УТҮГ	АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ	Өмнөх оны аудитаар шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, иж бүрэн байршуулах талаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй буюу шилэн дансанд 20 мэдээг хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан тул албан шаардлага хүргүүлэх.	1	-					1	-		

Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

9	Засгийн газрын авто бааз УТҮГ	АХГ-2022/133/НА-СТА-ТШЗ	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажилласандүгээр зүйлийн 21.1.Шалгагдагч эсэхийг шалгахад бичиг хэрэг, ажэтгээд хууль тогтоомж, захиргааны ахуйн зардлыг 8.1 хувиар буюу 1.9 сая төгрөгөөр, тээврийн зардлыг 58.6 хувиар буюу 24.8 сая төгрөгөөр, хоолны зардлыг 3.4 сая төгрөгөөр 100.0 хувиар нийт 30.1 сая төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтрүүлж зарцуулсан байв.	Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.Шалгагдагч хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан гэрчлэлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө; гэж заасны дагуу албан шаардлага өгөх.	1	-					1	-		
ДҮН					2						2	-		-
НИЙТ ДҮН					9	2,690,169.1	3	2,669,538.0			3	-	3	20,631.1



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 476/20150054
АХГ-2022/133/НА-СТЯ-ТӨААТҮГ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд бичиг хэрэг, аж ахуйн зардлыг 1,900,000.00 төгрөгөөр, тээврийн зардлыг 24,800,000.00 төгрөгөөр, хоолны зардлыг 3,400,000.00 төгрөгөөр, нийт 30,100,000.00 төгрөгөөр баталсан төсвөөс хэтрүүлж зарцуулсан.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах", 1.3 "төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүрэгээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Баталсан төсвийн хүрээнд хөрөнгийг зарцуулах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол-Ус ТӨААТҮГ-ын захирал Г.Билэгсайхан, Ерөнхий нягтлан бодогч В.Сэлэнгэ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Ж.ҮХЭРТАР

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тосируу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0315_Auditin_2_Gazar-177.Docx

0001001349



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 477/АО/50054

Улаанбаатар хот

АХГ- 2000/133/НА-СТА-ТООАТҮГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн ЗГХЭГ-ын дансанд бүртгэлтэй, өөрийн дансанд бүртгэлгүй автомашиныг ашиглан орлого олж, зардал гаргасан зөрчлийг арилгах албан шаардлага бүрэн хэрэгжээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 14.4.5 “бүх орлого” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. ЗГХЭГ-ын хөрөнгөд бүртгэлтэй 4 автомашины орлого, зарлагын тооцоо хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын авто бааз УТҮГ-ын захирал Г.Чинзориг, Ерөнхий нягтлан бодогч Т.Урантогос нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
НЬЮ ЭСТИМЭЙТОР АУДИТ ХХК-ИЙН
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА

Ж.ҮХЭРТАР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 478/20150054

Улаанбаатар хот

АХГ-0008/133/НА-СТА ТӨА АТҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8 дахь заалтын дагуу гүйцэтгэсэн Засгийн газрын авто бааз УТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 20 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”; 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хууль тогтоомжийг хэрэгжүүлж, мэдээллийг хуулийн хугацаанд ил тод, иж бүрэн байршуулж байх, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын авто бааз УТҮГ-ын захирал Г.Чинзориг, Ерөнхий нягтлан бодогч Т.Урантогос нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН:

ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

НЬЮ ЭСТИМАЙТОР АУДИТ ХХК-ИЙН

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Т.ГҮНЖИДМАА

Ж.ҮХЭРТАР

2022.03.15
001091351